



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠲᠠᠭ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 1/81

Алтай хот

**“Туульсын хаан Жангар” арга хэмжээнд  
хөрөнгө гаргах тухай”**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 10, 11 дүгээр тогтоол, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 07 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Нэгдсэн Үндэстний Байгууллагын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага буюу Юнеско-д 2009 онд бүртгэгдсэн Монгол тууль, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн А/759 дугаар тушаалаар батлагдсан Монгол Улсын яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өв болох Монгол Жангар хайлах өвийг хамгаалах, сурталчлах, өвлүүлэх, “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.4 дэх зорилгыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулагдаж буй “Туульсын өлгий Алтай” эрдэм шинжилгээний бага хурлыг хамтран зохион байгуулахаар Улаанбаатар хотоос ирж буй судлаач, эрдэмтдийн зардалд шаардагдах 7,500,000 (долоон сая таван зуун мянга) төгрөгийг хавсралтаар баталж, аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

2.Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилт, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР



ЗАРДЛЫН ТООЦОО

Аймгийн Засаг даргын 2023 оны  
 ... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар  
 захирамжийн хавсралт



№	Нэрс	Тоо	Мөнгөн дүн	Нийт дүн
1	ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн ЭША доктор (Ph.D) Т.Баясгалан, Төрийн батламжит туульч Н.Баатархүү, МУБИС-ийн багш Жангар судлаач, Доктор Одонбаатар	3 хүнд	1,000,000	3,000,000
2	Төрийн туульч, доктор Э.Баатаржав	1 хүнд	2,000,000	2,000,000
3	Хөтлөгч	1 хүнд	1,500,000	1,500,000
4	Замын зардал	5	1,000,000	1,000,000
НИЙТ ДҮН				7,500,000